

ТАНИЛЦУУЛГА

Хялбаршуулсан татварын тухай хуулийн төслийн талаар

Хялбаршуулсан татварын тухай хуулийн төсөл нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хөгжлийг татварын таатай бодлогоор дэмжих зорилгоор боловсруулагдсан. Энэ чиглэлд дараах 2 зорилтыг хангахыг зорьсон болно. Үүнд:

- Татварын дарамтыг бууруулах
- Татвар тайлагнах, төлөх үйл ажиллагааг хялбаршуулах

Хялбаршуулсан татвар гэдэг нь олон улсад хэрэглэгдэж буй “Упрощенная система налогообложения”, эсхүл “Simplified taxation system” гэдэг ойлголт юм.

Өндөр хөгжилтэй улс орнуудад “Simplified taxation system” гэх хялбаршуулсан татварын зохицуулалтыг татварынхаа ерөнхий хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт, өөрчлөлт хийх байдлаар зохицуулж явдаг ба тусгайлсан татварын горим болгон мөрддөггүй байна. Учир нь өндөр хөгжилтэй улс орнуудын хувьд жижиг, дунд бизнес эрхлэгчид нь тэдгээрийн бизнесийг голчлон авч явдаг, нийт ААН-ийнх нь 90%-иас дээш 98% хүртэлх нь ЖДҮ нар байдаг тул татварын хууль тогтоомж нь үндсэндээ эдгээр татвар төлөгчдөдөө зориулагдсан хууль байдаг байна.

Харин “Упрощенная система налогообложения” гэх хялбаршуулсан татварын систем нь 1990-ээд онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн орнуудад, тухайлбал ОХУ, Азербайжан, Армени, Беларусь, Казахстан, Киргизстан, Тажикстан, Узбекистан, Украин улсуудад хэрэглэгдэж байна.

Социалист систем нуран унаснаар түүний бүрэлдэхүүнд байсан манай улс болон бусад улс орнууд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үйл ажиллагаа эхэлсэн. Шилжилтийн анхны нөхцөл ямар байснаас хамаарч эдгээр улс орнуудад шилжилтийн явц харилцан адилгүй үр дагавруудыг авчирсан ба ТУХН-ийн орнууд болон Монгол улсад ерөнхийдөө ижил үр дагавартай байсан болно. Тухайлбал, шилжилтийн эхний жилүүдэд албан бус секторын хэмжээ маш хурдацтай өсч, эдийн засгийн бүтэц өөрчлөгдсөн. Нөгөө талдаа төрийн үйлдвэрүүд дампууран ажилгүйдэл нэмэгдэн, ЗГ-ын нийгмийн зардал өсөх хандлагатай болсон нь энэхүү зардлаа нөхөхийн тулд хувийн секторт илүү татварын дарамтыг бий болгосон.

Энэхүү шилжилтийн тодорхой нэг цаг хугацаа өнгөрч, үйлдвэрлэл буурч байсан бол эргээд өсч, хувийн сектор тодорхой хэмжээгээр тогтворжиж, албан бус сектороос албан секторт шилжих хүсэл сонирхол нэмэгдэх болсон тул үүнд зохицсон институцийн өөрчлөлт, бодлогын өөрчлөлтийг төрөөс авч хэрэгжүүлэх шаардлага тавигдсан.

Энэхүү шаардлагад нийцүүлэн ТУХН-ийн орнуудад “Упрощенная система налогообложения” буюу хялбаршуулсан татварын системийг авч жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулан 2004 оноос авч хэрэгжүүлсэн нь амжилттай хэрэгжиж байна. Энэ нь жижиг бизнес эрхлэгчдийн татварын дарамтыг багасгах, татварын нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг хөнгөвчлөх, хялбарчлахад хамгийн тохиромжтой татварын тусгай горим хэмээн хүлээн зөвшөөрөгдөөд байна.

“Хялбаршуулсан татварын тухай” Монгол улсын хуулийн төслийг улс орнуудад хэрэглэгдэж буй тус татварын тогтолцооны дэвшилтэт арга хэлбэрийг сонгон авч, өөрийн орны онцлогт нийцүүлэн боловсрууллаа.

“Хялбаршуулсан татварын тухай” хуулийн төсөл нь нийгэм, эдийн засаг дах тухайлсан харилцааны эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгож байгаа тул “анхдагч хуулийн төсөл” төрөлд хамаарч байна.

Тус хуулийн төсөл нь 8 бүлэг, 19 зүйл заалттай байхаар боловсруулагдсан болно. Эдгээр нь дараах харилцааг зохицуулж байгаа болно. Үүнд:

1. Хялбаршуулсан татварын тухай ойлголт

Хялбаршуулсан татварын системийг хэрэглэдэг бүх улс орнуудад тус систем дах татвар төлөгч нь үйл ажиллагааныхаа үр дүнгээр нэгдсэн нэг татвар төлдөг ба түүнд нь НӨАТ багтсан байдаг. Тус нэгдсэн нэг татварт НӨАТ-аас гадна үл хөдлөх хөрөнгийн албан татвар гэх мэт бусад татваруудыг багтаасан байдал нь улс оронд харилцан адилгүй байдаг байна. Эдгээр нь тухайн улс орны жижиг, дунд бизнес эрхлэгчдийн орлого үйлдвэрлэж буй онцлогтой холбоотой байдаг байна, тухайлбал үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг нэгдсэн нэг татварт оруулан тооцдог улс орнуудын хувьд жижиг, дунд бизнест эрхлэгч нь үл хөдлөх хөрөнгөө түрээслэн орлого олдог нөхцөл байдал нь харьцангуй их байдагтай холбоотой байдаг байна.

Манай улсын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ихэнх нь бусдаас бараа, бүтээгдэхүүн худалдан авч, түүгээрээ үйлдвэрлэл эрхлэн орлого олдог, эсхүл бусдад худалдан борлуулж орлого олдог нь түгээмэл тул хялбаршуулсан татварын системийн хүрээнд төлөх нэгдсэн нэг татварт орлогын албан татвар болон НӨАТ-ыг багтаан оруулах нь зүйтэй гэж үзлээ.

Энэ нь хуулийн төслийн 2 дугаар бүлгийн 2.2, 2.3, 2.4 дэх хэсгээр зохицуулагдаж байгаа болно.

Мөн бараг бүх улс орнуудад хялбаршуулсан татварын системд шилжин орох эсэх нь татвар төлөгчдийн сайн дурын үндсэн дээр хэрэгждэг байна. Хуулийн төслийг энэ зарчимд нийцүүлсэн бөгөөд хуулийн төслийн 2 дугаар бүлгийн 2.3 дах хэсэгт тусгаж өгсөн.

2. Хялбаршуулсан татварын системд хамрагдах хүрээ

Хялбаршуулсан татварын системд хамрагдах жижиг, дунд бизнес эрхлэгчдийг сонгох улс орнуудын үзүүлэлт, шалгуур янз бүр байдаг байна, тухайлбал борлуулалтын орлогын хэмжээ, ажиллагсадын тоо, үндсэн хөрөнгийн үнэлгээ, дүрмийн сангийн хэмжээ гэх мэт. Мөн тус системд хамрагдахгүй татвар төлөгчийн хүрээг тодорхойлсон байдаг ба эдгээр нь зээл, даатгал, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэгч, үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэгч, онцгой албан татвар төлөгч, хонжворт тоглоомын үйл ажиллагаа эрхлэгч гэх мэт.

Манай улсын хувьд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг Жижиг, дунд үйлдвэрийн тухай Монгол улсын хуулийн 5.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлж буй бөгөөд тус тодорхойлолтын “1,5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой” гэдэг шалгуурыг сонгон авч, тэдгээр нь явуулж буй бизнесийнхээ төрлөөс хамааран бүлгүүдэд хуваагдахаар Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт тусгалаа.

Харин хялбаршуулсан татварын системд хамрагдахгүй татвар төлөгчдийг Хуулийн төслийн 3 дугаар бүлгийн 3.4 дэх хэсэгт тодорхойлон тусгаж өгсөн бөгөөд үүнд бусад улс орнуудад түгээмэл хэрэглэгдэж буй шалгуурыг авахын зэрэгцээ “нэг компанийн охин болон харилцан хамааралтай компаниуд” байвал хамрагдахгүй эрхгүй болно гэж нэмж тусгаж өгсөн. Учир нь хялбаршуулсан татварын системд шилжихийн тулд компаниуд нь бүтцээ жижигрүүлэн, охин компаниудад хуваагдах байдлаар татвараас зайлсхийх үйлдэл гаргахгүй байхаас урьдчилан сэргийлсэн болно.

3. Хялбаршуулсан татвар төлөгч болох болон цуцлагдах нөхцөл байдал

Энэ үйл ажиллагааг Хуулийн төслийн 3 дугаар болон 4 дүгээр бүлгээр зохицуулахаар тусгалаа.

Хялбаршуулсан татварын систем нь татвар төлөгчийн дарамтыг 25%–40% орчим бууруулж байгаа тул буцаагаад татвар төлөгчөөс хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлэх хариуцлага нэхэх эрхтэй болж байгаа, энэхүү хариуцлагын асуудлыг түүний хялбаршуулсан татвар төлөгч болох эрхтэй нь холбож өгсөн болно. Тухайлбал, татвар төлөгч нь кассын машин заавал хэрэглэх, хэрэглэгчдэд НӨАТ-ын падаан хэвлэж өгөхийг Хуулийн төслийн 5.1.3-д, татвараа цаг хугацаанд нь төлж байхыг Хуулийн төслийн 5.1.4-д, тайлангаа хуулийн хугацаанд гарган ирүүлж байхыг Хуулийн төслийн 5.1.5-д гэх байдлаар тусгаж өгсөн.

4. Татвар ногдуулах объект

Хялбаршуулсан татварын систем дах татвар ногдуулах объект нь ихэнх улс орнуудад борлуулалтын орлого байгаа бол ОХУ, Азербайджан, Армени зэрэг улсуудад зардлаар бууруулсан борлуулалтын орлого байдаг байна.

“Борлуулалтын орлого”-ыг татвар ногдуулах объектоор сонгох нь татвараа тодорхойлж, төлөхөд татвар төлөгчийн хувьд ч тэр, татварын албаны хувьд ч тэр харьцангуй амар хялбар боловч “зардлаар бууруулсан борлуулалтын орлого”-ыг татвар ногдуулах объектоор сонгосон тохиолдолд харилцан адилгүй зардал гаргаж орлого олж буй бизнес эрхлэгчдийн хувьд ногдох татвар харьцангуй бодит тодорхойлогдох, түүнчлэн бизнес эрхлэгчид нь нягтлан бодох бүртгэлээ хөтөлж, орлого зардлаа үнэн зөв тодорхойлж сурах дадлыг хэвшүүлэх ач холбогдолтой байдаг байна.

Иймд “татвар ногдуулах объект”-ыг “зардлаар бууруулсан борлуулалтын орлого” байхаар сонгож Хуулийн төслийн 6 дугаар болон 8 дугаар бүлэгт тусгалаа.

5. Хялбаршуулсан татварын хувь, хэмжээ

Хялбаршуулсан татварын хувь, хэмжээг борлуулалтын орлогын 1% - 3,5% байхаар Хуулийн төслийн 7 дугаар бүлгийн 7.1 дэх хэсэгт тусгалаа.

Харин дээрх хувь хэмжээгээр ногдуулсан татварыг зардлын 0,6%-2,5%-иар бууруулахаар Хуулийн төслийн 7 дугаар бүлгийн 7.2 дах хэсэгт тусгалаа.

Ингэснээр ЖДБ эрхлэгчийн татварын дарамт 10,2%-15% болж байгаа ба энэ нь татварын ердийн горим дах татварын дарамтаас 19,1%-85,3%-иар буурахаар тооцоолол гарч байна.

Бүлэг	Татварын дарамт,% одоогийн хуулиар	Татварын дарамт,% татварын шинэчлэлээр	Хялбаршуулсан татварын горимын			
			ТНО-д татвар %	Зардлаар бууруулах %	Татварын дарамт,%	Буурах хувь,%
1 Импортлогч	34,1%	25,5%	1%	0,6%	15,0%	-19,1%
2 Жижиг худалдаа	71,4%	68,1%	2%	1%	14,7%	-56,7%
3 Нийтийн хоол	74,0%	58,6%	3,5%	2,5%	14,3%	-59,8%
4 Тээвэр	56,4%	50,9%	3%	2,5%	14,6%	-41,8%
5 ХАА	95,5%	83,6%	1%	0,5%	10,2%	-85,3%
6 Барилга	51,8%	45,8%	3%	2%	14,6%	-37,2%
7 НАА	78,9%	75,0%	2%	1%	14,9%	-64,0%

6. Татвар төлөх, тайлагнах харилцаа

Улс орнуудад хялбаршуулсан татварын системийн хүрээнд орлого, зардлын дүнг тодорхойлохдоо нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг хэрэглэх нь түгээмэл байдаг байна. Учир нь бараагаа борлуулаад мөнгөө авч амжаагүй байгаа үед татвараа төлөх шаардлага тавигдахгүй ба тэдгээрт санхүүгийн дарамт учрахгүй болно. Иймд хуулийн төслийн 9 дүгээр зүйлд “хялбаршуулсан татварын тооцоололд нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь хэрэглэнэ” гэсэн зохицуулалтыг тусгаж өглөө.

Хялбаршуулсан татварын систем дах татварын тайлагнал нь маш хялбаршсан байхын зэрэгцээ тайлагнах хугацаа нь зарим улс оронд жилээр, зарим улс оронд улирлаар байдаг байна. Тайлагнасан татвараа тайлант хугацаандаа багтаан төлөхөөр голдуу зохицуулагдсан байгаа хэдий ч татварын урьдчилгаа төлбөр төлөхөөр зохицуулсан улс орнууд ч байна.

Манай улсын хувьд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн сахилга бат сул, татвараа төлж дадаагүй, тэдгээрийг хянаж шалгах татварын албаны хүн хүч хязгаарлагдмал, чадавх муу зэргийг харгалзан үзээд татварын урьдчилгаа төлбөр төлөхөөр зохицуулалт хийж өгөх нь татвар төлөгчдөдөө ч тэр, татварын албанд ч тэр аль алинд хялбар байх болно гэж үзлээ.

Тухайлбал, татвар төлөгч нь тухайн тайлант жилийн өмнөх жилд ногдуулсан татварын дүнг 12-д хуваасан хэмжээгээр, харин шинээр үйл ажиллагаа эрхлэх гэж буй бол тухайн тайлант жилийнхээ борлуулалтын орлогыг төсөөлсөн дүнд ногдох татварыг тооцоолон гаргаж, нэг сард ногдох татварыг тодорхойлсон хэмжээгээр татвараа урьдчилан төсөвт төлж байхаар зохицуулалтыг Хуулийн төслийн 10 дугаар бүлгийн 10.1.2 дэх хэсэгт тусгаж өглөө.

Харин импортоор бараа оруулж ирэн, худалдан борлуулагч нарын хувьд бараагаа импортоор оруулж ирэх үедээ гааль дээр урьдчилан төлөхөөр зохицуулалт хийж өгвөл илүү амар байх болно гэдэг санал, санаачилга эдгээр татвар төлөгчдийн зүгээс гарч байсан тул энэ талын зохицуулалтыг Хуулийн төслийн 10 дугаар бүлгийн 10.1.1 дэх хэсэгт тусгаж өглөө.

Харин татварын тайлагналын хувьд жилдээ заавал тайлагнах, хүсвэл улирлаар тайлагнаж болно гэсэн сонголттойгоор зохицуулалт хийж өгвөл тайлагнал илүү хялбар болно гэж үзэн Хуулийн төслийн 11 дүгээр бүлгийн 11.1 дэх хэсэгт тусгаж өглөө.

Урьдчилгаа татвар нь хэтэрхий өндөр төлөгдөөд байгаа татвар төлөгчийн хувьд улирлаар тайлангаа гаргаж, илүү, дутуугаа тооцоод, илүү төлсөн татвараа дараа сарынхаа татварын урьдчилгаа татварт суутгуулаад тооцоод явах боломжтой байх зохицуулалтыг Хуулийн төслийн 10 дугаар бүлгийн 10.4, 10.5 дах хэсэгт тусгаж өглөө.

Харин татвар нь багцаалсан хэмжээнд төлөгдөж байгаа татвар төлөгчийн хувьд жилдээ нэг удаа тайлагнаад явах нь илүү амар хялбар болно.

7. Бусад харилцаа

Татвар төлөгч нь татварын харилцааг зохицуулж ирсэн ААНБОАТ-ын хууль, Хувь хүний орлогын албан татварын хууль болон НӨАТ-ын хуулийн хүрээнд татвараа төлж, тайлагнаж явах уу, эсхүл эдгээр татвараа хялбаршуулсан горимоор нэгтгээд төлж, тайлагнаж явах уу гэдэг нь өөрийнх нь сонголт байхаар Хуулийн төсөл зохицуулж байгаа. Иймээс татварын ердийн горимоос хялбаршуулсан татварын горимд шилжих, эсхүл хялбаршуулсан татварын горимоос татварын ердийн горимдоо буцаад

шилжих нөхцөл байдлууд үүсэх тул энэ талын харилцааг зохицуулсан зохицуулалтыг Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт тусгаж өглөө.

Дээр дурдсан бүх харилцааны хүрээн дэх зохицуулалтаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй татвар төлөгчид болон эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг Хуулийн 5 дугаар бүлэгт тусгаж өгсөн.

Хялбаршуулсан татварын тухай хуулийн төсөлд тусгагдсан тухайлсан харилцаануудыг, тухайлбал хялбаршуулсан татвар төлөгчөөр бүртгэх, хялбаршуулсан татвар төлөгчийн горимыг цуцлах, хялбаршуулсан татварын сарын урьдчилгаа татварыг тодорхойлж төлүүлэх, хялбаршуулсан татварын тайланг хүлээн авч, баталгаажуулах гэх харилцааны хүрээнд хийгдэх ажлын дэс дараалал, хөтлөх маягт, мэдэгдэх мэдээлэх зэрэг үйл ажиллагаануудыг нарийвчилсан журамласан журмыг батлаж мөрдүүлэх шаардлага үүсэх бөгөөд үүнийг Хуулийн төслийн Зургаадугаар бүлгээр зохицуулахаар тусгалаа.

Хуулийн төслөөр зохицуулагдах хялбаршуулсан татварын горимыг хүлээж буй хүлээлт ард иргэд, бизнес эрхлэгчдийн дунд их байгаа, тус горимоор зөвхөн зохицуулагдаж чадах хүндрэл, бухимдлыг цаг алдалгүй шийдвэрлэх үүднээс хуулийг 2018 ондоо багтаан буюу 2018 оны 3-р улирлаас эхлэн нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа болно. Иймд хялбаршуулсан татварын горимд оны дундуур шилжих шилжилтийн зохицуулалтыг Хуулийн төслийн Долоодугаар бүлэгт тусгаж өгсөн болно.

Ийнхүү хуулийн энэхүү өөрчлөлт, зохицуулалт нь нийгэмд нэн даруй шаардлагатай байгааг харгалзан тус хуулийг 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр Хуулийн төслийн Наймдугаар бүлэгт тусгаж өглөө.

Хуулийн төсөл нь Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар, Хувь хүний орлогын албан татвар болон Нэмэгдсэн өртгийн албан татварын хувьд тусгайлсан, шинэ горимын зохицуулалт хийж байгаа тул эдгээр дагалдах хуулиудад нэмэлт оруулж, Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсрууллаа.

___oooOOOooo___